

“ТЭЖЭЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

/ 2016 оны жилийн эцсийн байдлаар /

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2015 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн “Тэжээл” дэд хөтөлбөр		Хөтөлбөрийн зорилго: Нийслэлийн “Монгол мал”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрт тусгагдсаны дагуу хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, байгалийн болзошгүй эрсдлээс малыг хамгаалах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, өвс, тэжээл бэлтгэлийн хэмжээ, нэр төрлийг олшруулан, бэлчээрийн менежментийг сайжруулж, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, нийслэлийн хүн амыг мах, сүү болон стратегийн хүнсээр хангах нөхцлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		Нийслэлийн төсөв		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа/		НХХААГазар 2016-2021 онуудад хэрэгжинэ. 1-р үе шат 2016-2019 он, 2-р үе шат 2019-2021он		
4.	Хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Эрчимжсэн аж ахуйн мал, амьтны тэжээлийн орц, норм, тэжээллэг, жорыг зоотехникийн шаардлагын дагуу тогтоож, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. Зорилт 2. Нийслэлийн бэлчээрийн менежментийг сайжруулах замаар мал, амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, нөөц бүрдүүлэх, мал бүхий дүүрэгт өвс, тэжээлийг зөв хадгалах асуудлыг шийдвэрлүүлнэ. Зорилт 3. Тэжээл үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулан, шинжлэх ухааны дэвшилтэт технологи, төрөл бүрийн тэжээл бэлтгэх арга, туршлагыг нэвтрүүлэн мал, амьтны тэжээлийн хангамжийг нэмэгдүүлнэ. Зорилт 4. Эрчимжсэн цогц фермийн аж ахуйдад улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр шинээр худаг гаргах, засварлах замаар малын усан хангамжийг сайжруулна. Зорилт 5. Эрчимжсэн цогц фермийн аж ахуйн тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.		
5.	Зардал	Төсөв	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
	1-р зорилтын хүрээнд: 4.1.1. Хот орчмын фермийн аж ахуйн мал, амьтанд хэрэглэгдэх тэжээлийн жор, тэжээлийн орц, нормыг тогтоож, мал, амьтны төрөл, нас, хүйсэнд тохируулан тэжээх арга, технологи, зааврыг боловсруулах; 4.1.2. Мал аж ахуй эрхлэх бүс		Ажлын биелэлт: 4.1.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2016 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг тэжээлийн үйлдвэрүүдийн судалгааг авч нэгтгэсэн. Мал, амьтанд хэрэглэгдэх тэжээлийн жор, тэжээлийн орц, нормыг тогтоож, мал, амьтны төрөл, нас, хүйсэнд тохируулан тэжээх арга, технологи, зааврыг ХААИС, МААЭШХ-ийн судлаачидтай хамтран боловсруулан ажиллаж байна. 4.1.2 Нийслэлийн мал аж ахуй эрхлэх мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар 6 дүүргээс санал		

<p>нутагт бэлчээрийн менежмент хийж, мал аж ахуйн ерөнхий төлөвлөгөө, зураг, төсвийг холбогдох газруудтай хамтран боловсруулах ажлыг зохион байгуулах;</p>	<p>авч, ажлын танилцуулга, захирамжийн төслийг боловсруулан Засаг даргын 2016 оны А/463 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан ажиллалаа.</p> <p>“Тайшир өргөө”ХХК-тай хамтран ногоон тэжээл тариалах технологийг нутагшуулах зорилгоор Норвегийн “Жино”ХХК-ний тэжээлийн мэргэжилтэн Нийслэлийн фермерүүдэд мэдээлэл хийж, цаашид тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар тохирч төслийг боловсруулж байна.</p>
<p>4.1.3. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор эрхэлж буй цогцолбор фермүүдийн өндөр ашиг, шимтэй мал, амьтны тэжээллэгт өргөн ашиглагдаж байгаа ногоон тэжээлийн ургамлын үр тариалах талбайг холбогдох газруудтай хамтран шийдвэрлүүлэх;</p>	<p>4.1.3 “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна. Төслийн хүрээнд СХД-ийн 500 га газрыг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар ашиглахаар Засаг даргын 2016 оны А/79 дүгээр захирамжийг гаргуулан хашаалсан. Тариалалтын ажлыг 2017 оны хавраас эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>
<p>4.1.4. Мал, амьтны тэжээлийн төрөл, ангилалыг тогтоож, цогцолбор ферм аж ахуй бүрийн ногоон тэжээл үйлдвэрлэх стандарт, технологийг боловсруулж, мөрдүүлэх;</p>	<p>4.1.4 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p>
<p>4.1.5. Мах, сүүний үхэр, гахай, тахианы эрчимжсэн аж ахуй бүрт зориулалтын багсармал, холимог тэжээл үйлдвэрлэх стандарт, технологийг боловсруулж, мөрдүүлэх;</p>	<p>4.1.5 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: 4.2.1. Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, хот орчмын бэлчээрийн кадастрын зураглал, мэдээллийн санг бүрдүүлэх;</p>	<p>4.2.1 Бэлчээрийн кадастрын зураглал, мэдээллийн санг холбогдох газруудтай хамтран бүрдүүлээд байна.</p>
<p>4.2.2. Бэлчээрийн кадастрын зураглалын дагуу мал аж ахуй эрхлэх бүс нутаг болох хороодод эрчимжсэн мах, сүүний үхэр, гахай, тахиа, зөгийн цогцолбор аж ахуйдыг байгуулж, мал, амьтны ногоон тэжээлээр хангах техник, технологийг нэвтрүүлэх;</p>	<p>4.2.2 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор нийслэлд мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоож, уг 14 хороодод эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар хөтөлбөрт тусгасан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна.</p>
<p>4.2.3.Бэлчээрийн</p>	

<p>менежментийг сайжруулан хот орчимд зөвхөн эрчимжсэн фермийн аж ахуйг хөтөлбөрийн дагуу хөгжүүлэх;</p>	<p>4.2.3 Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг НИТХ-ын 2015 оны 32 дугаар тогтоолоор батлуулан төслийн нэгжийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Уг ажлын хүрээнд “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2014 онд батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
<p>4.2.4.Бэлчээрийн менежментийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн зохион байгуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, нутгийн удирдлагын байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, хөтөлбөр, журмын хэрэгжилтийг хангах, заалтыг жил бүрийн Засаг даргын үндсэн чиглэлд тусгуулах;</p>	<p>4.2.4 Мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг боловсруулан, тооцоо, судалгааг гарган холбогдох газруудаас санал авч, холбогдох материалыг бүрдүүлэн Засгийн газарт шийдвэрлүүлэхээр өргөн барьж ажиллалаа. Нийслэлд батлагдсан хөтөлбөр, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, 2017 оны нийгэм, эдийн засгийн зорилт, хөрөнгө оуулалтын саналд хөтөлбөр, журмыг хэрэгжүүлэх төсвийн саналыг тусган холбогдох газарт хүргүүлсэн боловч санхүүжилт батлагдаагүй.</p>
<p>4.2.5.Бэлчээрийн менежментийг сайжруулан бэлчээрийн мал аж ахуйг хот орчимд эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэх, төсөл, хөтөлбөр, журмыг батлуулан шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх;</p>	<p>4.2.5 Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын саналыг тусган холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: 4.3.1. Гадаад, дотоодын зээл, тусламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар тэжээлийн үйлдвэрүүдийг байгуулж, орчин үеийн техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн, тэдгээрийн сэлбэг хэрэгслийн хангамжийг сайжруулах;</p>	<p>4.3.1 ХХААХҮЯ-аас зарлагдсан төсөлд 5 аж ахуй нэгжүүдийг хамруулан дэмжиж ажиллалаа. Цаашид эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд тэжээлийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллаж байна.</p>
<p>4.3.2. Тэжээл үйлдвэрлэх арга технологийн талаар малчид, ферм эрхлэгчдэд сургалт зохион байгуулах, гарын авлага, мэдээллийн хэрэгсэл зэргээр сурталчлан таниулах;</p>	<p>4.3.2 “Тэжээл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тэжээлийн таримал ургамлыг тариалах технологи”-ийн сургалтыг ХХААЯ-тай хамтран Багануур дүүрэгт зохион байгуулж, сургалтанд 50 гаруй иргэд хамрагдаж, сургагч багшийн сертификат авлаа.</p> <p>2016 оны 02 дугаар сарын 1-ээс 7-ны өдрүүдэд газар, хэлтсийн дарга нар Норвеги Улсын Осло хотын Био эдийн засгийн судалгааны институтын зохион байгуулсан “Тэжээлийн чанар, малын эрүүл ахуй болон малын ген-тогтвортой сүргийн өсөлт хөгжилт” олон улсын семинарт оролцож, фермийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж,</p>

<p>4.3.3. Тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар хамтран ажиллах;</p> <p>4.3.4. Бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтад, шавьжтай байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглан тэмцэх;</p> <p>4.3.5. Уургийн агууламж ихтэй шинэ төрлийн таримал тариалах ажлыг өргөтгөх, газар тариалангийн дагавар бүтээгдэхүүнийг малын тэжээлд ашиглах технологийг боловсронгуй болгож, бага оврын цех байгуулах асуудлыг бодлогоор дэмжих, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх;</p> <p>4.3.6. Өвс, тэжээлийн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах баглаа, боодлын шинэ технологи нэвтрүүлэн овор багатай, чанар сайтай тэжээл бэлтгэж, өвс, тэжээлийн байнгын нөөц бүрдүүлэх;</p> <p>4.3.7. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд таримал бэлчээр, хадлангийн талбай эзэмшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>4.3.8. Нийслэлийн малыг хонин толгойд шилжүүлснээр нийт малд шаардагдах бэлчээрийн зохистой хэмжээг байгаль, цаг уурын бүсээр тогтоож, бэлчээрийн газрын төлөв байдлын ашиглалтын үнэлгээг жил бүр тодорхойлж байх;</p>	<p>туршлага судаллаа. Хэлтсийн мэргэжилтэн Б.Гантулга, О.Батжаргал нар БНХАУ-д мал аж ахуйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдлаа.</p> <p>4.3.3 Тэжээл үйлдвэрлэлийн нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоод, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар төслийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>4.3.4 ХХААХҮЯ-тай хамтран ажиллах санамж бичигт уг асуудлыг тусгуулахаар саналаа хүргүүлсэн. Уг ажилд зарцуулагдах санхүүжилт байдаггүйгээс энэ ажил удаашралттай байна.</p> <p>4.3.5 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p> <p>4.3.6 Нийслэлд өвс, тэжээлийн байнгын нөөцийг бүрдүүлэх чиглэлээр 2015 онд Засаг даргын нөөцөөс 200 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн мал бүхий 6 дүүрэгтэй гэрээ байгуулан ажилласан. Уг санхүүжилтээс Багануур дүүрэгт өвс, тэжээл нөөцлөх агуулахыг бариулж ашиглалтанд оруулсан.</p> <p>4.3.7 Ферм эрхлэгчдийг хадлан бэлтгэх нөхцлөөр хангах чиглэлээр аймаг, орон нутгийн удирдлагуудад тодорхой чиглэл өгч ажиллалаа.</p> <p>4.3.8 Нийслэлийн малыг хонин толгойд шилжүүлснээр нийт малд шаардагдах бэлчээрийн зохистой хэмжээг 2016 оны байдлаар гаргасан бөгөөд Нийслэлд бэлчээрийн даац 5 дахин хэтэрсэн дүнтэй гарсан. УЦУЭШХ-ээс гаргадаг бэлчээр ашиглалтын төлөв байдлын судалгааг мал бүхий 6 дүүрэгт хүргүүлэн арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл өгсөн.</p>
--	--

<p>4.3.9. Нийслэлийн мал бүхий 6 дүүрэгт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлж, хадгалалтын горимыг мөрдүүлэх ажлыг холбогдох газруудтай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлэх;</p>	<p>4.3.9 Засгийн газрын 322, Нийслэлийн Засаг даргын 02 албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн мал аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд мал бүхий 6 дүүрэгт өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх ажлыг Дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж ажиллалаа.</p>
<p>4-р зорилтын хүрээнд: 4.4.1. Малын усан хангамжийг сайжруулж, судалгааны ажлыг малчдын санал, санаачилгыг харгалзан улсын төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, тухайн цэгт шинээр ус нөөцлөх сан бүхий худаг гаргах;</p>	<p>4.4.1 Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн хороодод дүүргүүдийн ЗДТГазартай хамтран бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар шинээр гаргасан инженерийн хийцтэй 154 худгийн судалгааг гаргалаа. Худаг гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж ажиллаа. 2016 онд СХД-ийн 21 дүгээр хорооны нутаг “Бэлчээрийн менежментийн үйлдвэрлэлийг сайжруулах хөтөлбөр”-ийн газарт 2 ширхэг ус нөөцлөх сан бүхий худаг гаргалаа.</p>
<p>4.4.2. Шинээр худаг гаргахад шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг ашиглагчдаас нь гаргуулах замаар ашиглагчдын хариуцлагыг өндөржүүлэх;</p>	<p>4.4.2 Мал бүхий 6 дүүрэгт бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 2014 онд улсын төсвөөр 10 ширхэг, 2015 онд нийслэлийн төсвөөр 10 ширхэг худгийг гаргаж, оролцооны 0,5%-ийг малчдаас гаргуулж, хариуцан ажиллах иргэдэд хүлээлгэн өгсөн.</p>
<p>4.4.3. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргасан болон сэргээн засварласан худгийн цаашдын ашиглалт хамгаалалт, засварын ажлыг тухайн эзэмшигчид хариуцуулж, хоршоонд гэрээгээр ашиглуулах;</p>	<p>4.4.3 Нийслэлийн нутаг дэвсгэрт 2014-2015 онуудад улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гаргасан инженерийн хийцтэй 20 ширхэг худгийн гүйцэтгэлийн баримт бичгийг эх хувиар нь 4-р сарын 14-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн. Ашиглах, хариуцан ажиллахыг дүүрэг хариуцан ажиллаж байна.</p>
<p>5-р зорилтын хүрээнд: 4.5.1. Эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт эрхлэн, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;</p>	<p>4.5.1 Нийслэлд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх чиглэлээр дүүрэг бүрт ажлын чиглэл өгч, төлөвлөгөө гарган ажиллалаа. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах зорилгоор Мал хамгаалах санд татан төвлөрүүлсэн санхүүжилтээр энэ онд 125 тн өвс, 27 тн тэжээлийг аюулгүйн нөөцөд бэлтгээд байна.</p>
<p>4.5.2. Тэжээл, өвс бэлтгэх хурдавчилсан технологи нэвтрүүлж, өндөр нягтралтай боох, нийлэг уутанд дарш хийх, олон найрлагат уурагжуулсан, витаминжуулсан тэжээл үйлдвэрлэлийг дэмжих;</p>	<p>4.5.2 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p>
<p>4.5.3. Эрчимжсэн мал аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр гадаадад нарийн мэргэшлийн мэргэжилтэн</p>	<p>4.5.3 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p>

<p>бэлтгэх, давтан сургах;</p> <p>4.5.4. Хөдөө аж ахуйн чиглэлийн их, дээд сургуулиудад эрчимжсэн аж ахуй, тэжээлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх талаар холбогдох газруудтай хамтран ажиллах;</p> <p>4.5.5 Уурагт, багсармал, холимог, зоодойлсон болон хорголжин тэжээл үйлдвэрлэх тэжээлийн бага, дунд оврын цех байгуулахад бодлогоор дэмжих;</p>	<p>4.5.4 ХААИС-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар төслийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>4.5.5 Хөтөлбөрийн 2 дах үе шатанд хэрэгжүүлнэ.</p>					
<p>7. Дүгнэлт/ололт, анхаарах асуудлууд/</p>	<p>“Тэжээл” дэд хөтөлбөрийн хэрэгжилт удаашралттай байгаа нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд уг хөтөлбөрт зарцуулагдах төсвийн саналыг тусган холбогдох газарт хүргүүлдэг боловч улсын болон орон нутгийн төсөвт хөтөлбөрт зарцуулах санхүүжилт тусгагддаггүйтэй холбоотой юм.</p>					
<p>8. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>						
<p>9. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ(Өөрийн үнэлгээ)</p>	<p>Биелэлт дундаж</p>	<p>Зорилтын тоо</p>	<p>Зорилт 1</p>	<p>Зорилт 2</p>	<p>Зорилт 3</p>	<p>Зорилт 4</p>
<p>10. өсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ/нэгдсэн үнэлгээ/ЗГХЭГ-ын үнэлгээ/</p>		<p>Нэгдсэн үнэлгээ</p>				
		<p>%</p>				

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА

Д. БАЯНБАТ

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

ЭМАА ХЭЛТСИЙН ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЭМААХ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХТУЯА